



Санамжийн хуудас

Сүрьеэ өвчин

Өвчтөн хэдийгээр хэдхэн долоо хоногийн дараа бие нь сайжирсан шинжтэй байсан ч эмнүүдээ бүхэл цагийн турш зааснаар өдөр бүр уух хэрэгтэй. Хэрэв эмээ уух дэг журмыг сахихгүй бол өвчин дахин газар авч, өвчнөө дахин орчны хүмүүстээ халдааж эхэлнэ. Түүнчлэн өвчин эмэндээ дасаж эм үйлчлэхээ больж найдвартай эдгэрэхгүйд ч хүрч болзошгүй.

Өвчтөний идэвхтэй оролцоогүйгээр өвчин ямар ч сайн эм хэрэглээд үр дүн гарахгүй!

Өвчин халдварласан боловч өвчлөөгүй хүмүүсийг илрүүлэх нь

Халдварт өвчнөөр өвдсөн хүнтэй хамгийн ойр байгсадаас (үүнд гэр бүлийн гишүүд, найз нөхөд, танил хүмүүс, хамт ажиллагсад орно) шинжилгээ авах хэрэгтэй. Учир нь тэд халдвар авч, цааш нь бусдад халдааж болно.

Танд сүрьеэгийн бактериуд халдсан эсэхийг тодорхойлох эмчийн үзлэгийн ямар арга хэлбэрүүд байдаг вэ?

Өвчин халдсанаас хойш 2 сар орчмын дараа арьсны, цусны сорил авч шинжлэн сүрьеэгийн бактериудыг илрүүлнэ.

1. Сүрьеэгийн сорил (мантокс)

Сүрьеэгийн сорил нь арьсан дээр тухайлбал шуун дээр наадаг сорил юм. Сорил тавьсан газар 3–7 хоногийн дараа хатуурал үүсвэл сүрьеэгийн бактери халдсаны нэгэн шинж.

2. Цусны сорил (гамма интерферон сорил)

Лабораторид цусны сорилыг өвчний халдвартай эсэхийг шинжилж үздэг. Уг сорилыг шинжлэхдээ зөвхөн сорил өгөгчтэй тохиролцсон үед ДОХ-ын шинжилгээ хийнэ.

Дээрх хоёр сорилын аль нэгэнд нь халдвар илэрвэл өвчин газар авахыг эмээр саатуулж болно. Энэ нь бага насны хүүхдүүд болон дархлалын сулралтын өвчин ДОХ-той хүмүүст маш чухал. Бага насны хүүхдүүдийг сорилын хариуг харгалзалгүй эмчилж эхлэх нь ихэвчлэн найдвартай байдаг.

Сүрьеэ өвчин гэж юу вэ?

Сүрьеэ өвчин нь сүрьеэ өвчний бактериар халддаг халдварт өвчин. Түүний хамгийн тархмал хэлбэр нь уушигны сүрьеэ өвчин юм. Хэн нэг өвчилсөн хүн гэр бүлдээ эсвэл бусад хүмүүст өвчнөө халдааж болно. Сүрьеэ өвчин ялангуяа бага насны хүүхдүүд, эсэргүүцэл нь суларч доройтсон хүнд аюултай. Гэвч түүнийг зөв эмчилвэл эдгэрдэг.

Халдварлалт

Сүрьеэ өвчин амьсгалын замаар хүнээс хүнд халддаг. Өвчилсөн хүн ханиахад сүрьеэгийн бактериар маш жижиг дуслууд агаарт тархана. Үүнийг нь өөр хэн нэгэн хүн амьсгалын замаар өөртөө авна. Уушигны сүрьеэ өвчтэй хүнтэй ойр байхад халдах аюул бий. Уг ойртолт хамгийн ойр дөт, хамгийн удаан байх тутам халдах аюул ихсэнэ. Ханиалганаас нь лабораторын микроскопд сүрьеэгийн бактерийг олж харах боломжтой болсон хүнийг энэ өвчнөөр өвдсөн хүн гэж хэлнэ.

January 2007



Swiss Federal Office
of Public Health



SWISS LUNG ASSOCIATION



Өвчлөлт биенд тархах нь

Сүрьеэгийн бактери нь амьсгалаар биед дамжин орж уушгинд байрлана. Ингэж халдвар авсан хүмүүсийн ихэнх нь (90% орчим) өвчнийг биедээ агуулж өөрөө өвдөхгүй байдаг. Нөгөө 10 хувьд багтах хүмүүсийн уушгинд хэдэн долоо хоног, хэдэн сар, хэдэн арван жилийн дараа бактер үржиж эхэлдэг. Жижиг хүүхдүүд (5 наснаас доош) эсвэл дархлалын сулралтын өвчтэй (ж: ДОХ-той) хүмүүсийн өвчлөх нь илүүтэй бөгөөд тэд илүү хүндээр өвддөг. Уушигны рентгений зураг дээр өвчтэй хэсэг ихэвчлэн бараантаж харагддаг. Өвчтэй хүний ханиалгаар уг өвчин бусдад халдана.

Уушгаар дамжин бактериуд нь бусад эрхтэнүүдэд очиж тэндээ сүрьеэг үүсгэж болно. Жишээлбэл: тунгалагийн булчирхайн зангилаа уулзваруудад (ихэвчилж хүзүү хавиар), тархинд, ясанд, гэдэс дотор эрхтэнд.

Өвчний шинж тэмдгүүд

Өвчлөлт ихэвчилж бага зовиуртай эхэлдэг.

Доорх зовиурууд илэрнэ:

- ханиалга, заримдаа цустай холилдсон
- туралт
- хоол унданд дургүй болох
- ядрах
- хөнгөн халууралт
- шөнөдөө хөлрөх
- цээж хавиар өвдөх

Сүрьеэгээр өвчилсөн хүн тэр болгон хүндээр өвчилсөн мэт санагддаггүй. 2–3 буюу түүнээс дээш долоо хоног ханиалгах болон бусад дээр дурдсан шинжүүд илэрвэл даруй эмчид үзүүлэх хэрэгтэй.

Сүрьеэ өвчний оношлол

Таныг сүрьеэгээр өвчилсөн эсэхийг тодорхойлох эмчийн үзлэгийн ямар арга хэлбэрүүд байдаг вэ?

1. Сүрьеэгийн бактерийг эрэх

Бактерийг өвчтөний цэрэнд (мокрота) эрдэг. Лабораторид уг ялгадсыг будахад бактериудыг микро-

скопоор харах боломжтой болно. Заримдаа хэдэн долоо хоног үржүүлсний дараа харах боломжтой болдог. Үүний тулд цэр ялгадсыг лабораторид үржүүлэх орчинд (культурт) байлгана.

2. Уушигны рентгений зураг авах

Рентгений зураг дээр ямар нэг ердийн бус байдал гарсан бол тэр нь сүрьеэ өвчний тэмдэг байж болно; гэвч бусад өвчний шинж тэмдэгтэй төстэй байдаг тул найдвартай оношлох боломжгүй. Тиймээс нэмэгдэл болгож цэр ялгадсыг лабораторид шинжлэх хэрэгтэй.

3. Уушиг дурандах (бронхоскопоор)

Хэрэв бактери илрэхгүй бол эцсийн оношилгоо хийхэд уушиг дурандах шаардлагатай. Үүний тулд амьсгалын замаар нарийн гуурс зонд оруулж дурандана. Үүний хажуугаар лабораторид зориулж сорил авна.

Сүрьеэ өвчнийг эмчлэх нь

Эмчилгээний зорилго нь сүрьеэгийн бактерийг устгах явдал. Эмчилгээ ердийн тохиолдолд тусгай эмүүд ууж 6 сар үргэлжилнэ. Учир нь өвчний бактериуд эмчилгээний үйлчилгээг авахдаа маш удаан.